



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А144

Хэрлэн сум

Ажлын гүйцэтгэл удааширч царцсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа царцсан төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж, ажлыг дуусгаж ашиглалтад оруулахад шаардлагатай санхүүжилтийг төсөвт тусгуулж шийдвэрлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн
дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Зарлагын мэргэжилтэн

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, орон сууц, газрын харилцааны бодлого хариуцсан мэргэжилтэн

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

2. Үйл ажиллагааны хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, ахиц гарсан үр дүнг тухай бүр танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ДАЮУРБУНЬ



D:\My Documents\Захирамж-2025

231010133

